# ТӨРИЙН БОДЛОГЫН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Дэмбэрэл
Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа

***Товч агуулга:*** *Энэхүү өгүүллээр иргэдийг идэвхижүүлэх, өөрөөр хэлбэл иргэд өөрсдийн санал санаачилгаар шийдвэрлэж чадах асуудлаас төрийг ангижруулах асуудлыг судлахыг зорилоо.*

***Түлхүүр*** үгс:Төрийн бодлого, хэлбэр, иргэдийн оролцоо, мөн чанар, иргэний нийгэм

## Оршил

Иргэд улс төрийг бага сонирхдог. Тэд өөрийн гэсэн амьдралтай, ажил эрхлэх гээд төрийн бодлогын мөн чанар, ач холбогдлыг тайлж мэдэх зав тун хомс. Иргэдийн оролцооны утга учир, чиг хандлагыг тэр болгон ойлгож ухаарсан иргэд ч бас ховор. Нийгэмд иргэд “улс төрөөс" уйдаж, залхах хандлага ямагт давамгайлж байдаг. Улс төрд зохисгүй агуулга оруулан нийгэмд нэвтрүүлснээр иргэд түүний мөн чанрыг ташаа ойлгож, “бохир” гэсэн тодотгол өгч, хүн ойртох хэрэггүй “орчин” хэмээн үздэг. Үүний үр дүнд төрийн бодлогын үйл явцад оролцох, нийгэм улс гүрнээ гэсэн бодолтой иргэдийн оролцоо багасаж, “улс төрийн элит нэртэй” олигархи “хар” хэргээ гүйцэлдүүлэх боломж нээгддэг. Ийм нөхцөлийг өөрчлөх гэсэн эрүүл хүч идэвхжиж хаяа сэрдэг ч гэсэн тодорхой хийх ажил нь онолын үндэслэл хийгдээгүй учир амжилтанд хүрэлгүй замхардаг тохиолдол цөөнгүй юм. Улс төр, нийтийн удирдлагын ямар ч ойлголт өөрийн гэсэн агуулгатай мөн хэрэглээний зориулалттай байдаг гэдгийг анхаарах нь зүйтэй гэдэг үүднээс дээрх сэдвийн хүрээнд нарийвчлан тодотгол хийхийг зорилоо.

## Нэг. Иргэдийн оролцоо, түүний зарим хэлбэр

Алдарт сэтгэгч Т.Гоббсын хувьд гэрээ төрийн мөн чанарыг нээн гаргахад иш үндэс болгосон ойлголт бөгөөд гэхдээ бусад нийгмийн гэрээний төлөөлөгчдөөс ялгагдах онцлог нь түүнийхээр бол гэрээ хүмүүсийн хооронд хийгдэх ёстой байв. “Ер нь иргэн ард түмэн хооронд хэлэлцээр байдаггүй, тэгэхлээр ийм гэрээ хэлэлцээр иргэд хооронд байгуулагдана. Өөрөөр хэлбэл, чи миний төлөө эрхээ ард түмэнд шилжүүлэн өгөхийн тулд би өөрийн эрхийг чиний төлөө ард шилжүүлж өгч байна гэсэн байдлаар хүмүүс хандсан тэр нөхцөлд иргэн бүр өөрийн хүсэл зоригийг олонхийн хүсэл зоригт захирууллах үүргийг хүлээх болно” хэмээн тэр бичсэн байдаг.

Ийнхүү төр, иргэдийн хоорондын харилцааны тодорхойлогч хүчин зүйл нь харилцан бие биенээ нухчин дарах бус, харин харилцан эрх чөлөөтэй байхад оршинэ гэсэн санааг тэрээр дэвшүүлсэн юм. Төр засгийн зүгээс хүч хэрэглэх нь гол төлөв улс оронд энхийг тогтооход чиглэгдэнэ. Учир нь энх тайван бол хүн байгалиас өөрт заягдсан авьяас чадвартаа түшиглэн хөгжих боломж олгодог

тулгуур үнэт зүйл мөн тул төр иргэддээ эрх чөлөөг байх хэмжээнд нь саадгүй олгох ёстой[1] гэсэн байдаг.

Иргэн буюу нийгмийн гишүүн нь тухайн нийгэмд тодорхой үүрэг, хариуцлага хүлээдэг. Хуульд иргэний эрхийн талаар тусгасан байдаг ч үүрэг хариуцлагуудыг сайн тодорхойлоогүй нь иргэдийн дунд үүрэг, хариуцлагын талаарх зөрүүтэй ойлголт гарахад хүргэдэг[1] [2]. Тухайлбал, санал өгөх нь үүрэг, хариуцлага гэж тусгасан байж болох ч заавал биелүүлэх албагүй. Түүнчлэн иргэний оролцоог тодорхойлохын тулд “оролцоо” хэмээх ухагдахууныг тодорхойлох нь зүйтэй. Оролцоо улс төрийн, эдийн засгийн менежментийн болон бусад нийгмийн шийдвэрүүдэд олон нийтийн оролцох хэлбэр, арга хэрэгслүүдийг багтаасан нийгмийн шинжлэх ухааны өргөн ойлголт[3].

Иргэдийн оролцоо нь эртний Грек, Ромын үеэс ардчиллын гол үнэт зүйл байсан төдийгүй улс төр судлалын нэгэн судлагдахуун. Орчин үед иргэдийн оролцоо зөвхөн улс төрийн шинжлэх ухааны төдийгүй социологи, эрх зүй, эдийн засаг, олон улсын харилцаа, нийтийн удирдлага зэрэг шинжлэх ухааны судлагдахуун болон хөгжсөн. Сүүлийн жилүүдэд шууд ардчилал, иргэдийн оролцооны тухай хөндөгдөх болсон нь засаглалын үзэл баримтлалын хүрээнд үнэ цэнэтэй хэрэгсэл болж байна. Иргэдийн улс төрийн шийдвэрт сэтгэл хангалуун бус байдал, иргэдийг төлөөлж бүх түвшинд суудал авсан улс төрчид иргэдийг бүрэн төлөөлж чадахгүй гэж үздэгтэй холбоотой[4].

Иргэдийн оролцооны ойлголтын талаар эрдэмтэн, судлаачдын байр суурь өөр өөр байдаг нь өнөөг хүртэл нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй. Иргэдийн оролцоо бол хүн төрөлхтний түүхийн явцад хамтын ажиллагааны зохион байгуулалтын дээд хэлбэрт хүрэх тэмүүлэл[5]. Улс төрийн шийдвэр гаргах үйл явц болон томоохон төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх явцад иргэдийг оролцуулахыг иргэдийн оролцоо гэж тодорхойлдог. Иргэний идэвхтэй оролцоо ардчиллын суурь үнэт зүйл, түүний мөн чанарын илэрхийлэл бөгөөд ардчиллын гол хөдөлгүүр[6]. Иргэдийн оролцоо нь ардчиллын оршин тогтнох, сүүлийн тулах цэг гэж эрдэмтэн Густав Де Коккү тодорхойлсон.

Иргэдийн оролцооны түвшин, цар хүрээ нь улс орон бүрт харилцан адилгүй төдийгүй тухайн улсын улс төрийн систем болон соёлын илэрхийлэл. Үзэл

[1] Ё.Довчин “Т.Гоббс: Төр, иргэний харилцаа" Политологи" ЭШ-ний бичиг №189 /15/ УБ., 2002 он. 14 дэх тал

[2] Angelita Gregorio-Medel; Иргэдийн оролцоо ба чадавхын хөгжүүлэлт, NUM leadership олон улсын эрдэм шинжилгээний хуралын эмхэтгэл, УБ., 2014. 62 дахь тал

[3] Мягмарцоож Н; Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо, Улаанбаатар 2012. 1 дэх тал

[4] Батсүх Ш ; Ардчилалд иргэдийн идэвх, оролцоо чухал болох нь сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралын эмхэтгэл, Улаанбаатар 2015. 11 дэх тал

[5] Батсүх Ш, Доржжав Я. Ганцоож Б; Шууд ардчилал иргэдийн оролцоо, Улаанбаатар 2014. 17 дахь тал

[6] Мягмарцоож Н; Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо, Улаанбаатар 2012,. 8 дахь тал

суртал болон хувийн эрх ашигт тулгуурласан оролцоо нь иргэдийн оролцоо мөн бөгөөд хүний үндсэн эрхийг дэмжих чухал ач холбогдолтой.

Иргэдийн оролцоо нь олон нийтийн оролцоотой адилгүй. Шийдвэр гаргах үйл явц дахь олон нийтийн оролцооны нийтлэг аргачлал, арга зүй нь дээрээс доошоо чиглэсэн үйл явцыг тусгах ба оролцогч талуудын хамтын ажиллагааны давуу тал болон олон нийтийн утга учиртай оролцоог бүрэн дүүрэн бүрдүүлдэггүй[7]. Оролцоог хангах ардчилсан сонголтыг хаагдуулж, засгийн газрын зүгээс суурь нийгмийн болон аж ахуйн үйл ажиллагаанд хэт давамгайлж оролцох нь том төрийн Үндсэн шинжийн нэг[8]. Харин оролцоог дэмжих нь сайн засаглалын шинж бол оролцоогоо ухамсарласан ухаалаг иргэд нь ухаалаг төрийн хэмжүүр юм. Ухаалаг иргэд [9]нь эрх, үүргээ ухамсарладаг, иргэдийн оролцоо чухал болохыг ойлгодог, боловсролтой иргэдийг ойлгоно. Итгэлцэл, ил тод байдал, оролцоог хангасан байдал ухаалаг төрийн илэрхийлэл. Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэдийн төрд итгэх итгэл чухал нөлөөтэй. Ухаалаг төр иргэдийн итгэлд түшиглэдэг бөгөөд иргэд төрийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг[10] [11] [11].

Иргэдийн оролцоо хуулиар тогтоосон албан ёсны, иргэдийн сайн дурын буюу албан бус гэсэн хоёр хэлбэртэй. Иргэдийн оролцооны албан ёсны хэлбэрийг хуульчилсан байдаг. Жишээлбэл, иргэд ямар үе шатанд яаж оролцох, ямар хил хязгаарыг давахгүй байх зэрэг нарийн зохицуулалтыг тодорхойлдог. Орон нутгийн түвшинд албан ёсны оролцоо нь иргэд шууд ардчиллын замаар иргэдийн хурал болон захиргааны байгууллагуудад өргөдөл гарган хүсэлт тавих замаар асуудлаа шийдүүлэх нь иргэдийн санаачлага. Мөн нийт иргэдийн санал асуулга явуулж, олонхийн саналаар асуудлыг шийдэх арга бас бий[11]. Албан бус оролцоо: иргэдийн оролцооны албан бус хэлбэр ихэвчлэн иргэдийн санаачлагаар зохион байгуулагддаг[12].

Гэхдээ тэдний сайн дураараа оролцож зохион байгуулсан ажлын үр дүн улс төр, захиргааны шийдвэрт заавал түсгагддаг байх ёстой. Иргэдийн оролцоо олон үе шаттай. Иргэдийн оролцооны үе шат доороос дээш Америкийн судлаач Ш.С. Арнштайны боловсруулсан загварын зорилго нь улс төр, захиргааны байгууллагын зүгээс шийдвэр гаргахад иргэдийг оролцуулах явдал. Энэ загвар оролцооны чанарын асуудлаар ямар ч мэдээлэл өгдөггүй боловч улс төр,

[7] Angelita Gregorio-Medel; Иргэдийн оролцоо ба чадавхын хөгжүүлэлт, NUM leadership олон улсын эрдэм шинжилгээний хуралын эмхэтгэл, Улаанбаатар 2014. .69 дэх тал

[8] Jan Ziekow; Том төрөөс ухаалаг ухаалаг төр лүү шаардлагатай чадавхыг хөгжүүлэх нь, NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Улаанбаатар 2014. 27 дахьтал

[9] Jan Ziekow; Том төрөөс ухаалаг ухаалаг төр лүү шаардлагатай чадавхыг хөгжүүлэх нь, NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2014. 23 дахь тал

[10] Jan Ziekow; Том төрөөс ухаалаг ухаалаг төр лүү шаардлагатай чадавхыг хөгжүүлэх нь, NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2014. .33 дахь тал

[11] Батсүх Ш, Доржжав Я, Ганцоож Б; Шууд ардчилал иргэдийн оролцоо, УБ., 2014. 21 дэх тал

[12] Мөн тэнд

захиргааны байгууллагын зүгээс иргэдийг ямар үе шатанд хэрхэн оролцуулахыг шийдэхэд тусалдаг[13].

Иргэдийн оролцоог доод түвшингээс дээд түвшин хүртэл дэс дарааллаар үзвэл [14] Мэдээлэл олон нийт шийдвэр төлөөлөгчийн тухай мэддэг байж, төлөвлөгч болон олон нийтийн хоорондын харилцааны жирийн хэлбэрүүд энэ нь иргэдийн оролцооны доод түвшин боловч оролцогчдын тоо харьцангуй их байдаг зүй тогтолтой. Иргэдийн буцах холбоо: нэмэлт мэдлэг эсвэл үнэлний асуудлаар төлөвлөгч олон нийтийн санал болон мэдээллийг авах, судалгаанууд зэрэг байдаг. Зөвлөлдөөн төсөөтэй асуудлууд болон үйл явцыг дүгнэхэд төлөвлөгч болон олон нийтийн хооронд албан ёсны яриа хийх, олон нийтийн уулзалт, ажил хэргийн уулзалт, нээлттэй танхим ажиллуулах зэргийг зохион байгуулж болно. Иргэдийн оролцооны түвшин болон оролцогчдын тоо урвуу хамааралтай. Оролцооны түвшин нэмэгдэхэд оролцогчдын тоо буурч, оролцогчдын тоо нэмэгдэхэд оролцооны түвшин буурч илэрдэг.

**Зураг 1. Иргэдийн оролцооны пирамид**




## Хоёр. Иргэдийн оролцоо ба иргэний нийгэм

Иргэний нийгэм хувь хүмүүсийг бүтээлчээр нийгмийн сайн сайхан аюулгүй байдлын төлөө хамтран ажиллаж, амьдрахад тусладаг. Сайн иргэний нийгэм оршин буй эсэхийг ардчилсан төрийн үйл ажиллагаатай холбон иргэний нийгэм иргэдийн санал, санаачлага болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах байдлаар илэрдэг. Иргэдийн эрх ашиг ноцтой зөрчигдсөн, ялгаварлан гадуурхалт

[13] Батсүх Ш, Доржжав Я, Ганцоож Б; Шууд ардчилал иргэдийн оролцоо, УБ.. 2014. 20 дахь тал
[14] Мягмарцоож Н; Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо, УБ., 2012. 20 дахь тал

даамжирсан зэрэг сөрөг үзэгдлүүдийн эсрэг тэмцэл хөдөлгөөн хэлбэрээр илэрдэг онцлогтой.

Иргэний нийгмийн байгууллага: төр, гэр бүлийн хоорондхи орон зайд үйл ажиллагаа явуулдаг, сонирхол, үнэт зүйлээ хамгаалах, хөгжүүлэх хүсэл бүхий нийтийн байгууллагууд[15]. Мөн гэр бүл, бизнесийн бүлэглэл (төрөөс ангид) үйл ажиллагаа явуулж буй институцуудын нийлбэр цогц[16]. Иргэний нийгэм нь иргэний нийгмийн байгууллагууд, төрийн болон бизнесийн байгууллагын хамтын ажиллагааны үр дүн бөгөөд хамтын оролцоотой, хариуцлагатай, тайван замаар өөрчлөлт хийх механизмыг бий болгож орон нутагт аюулгүй, үр бүтээмжтэй, шударга нийгмийг бэхжүүлэх нь чухал[17]. Иргэний нийгмийн гүйцэтгэх үүргүүд[18]:

- Ардчиллыг бэхжүүлэх;
- Эдийн засгийн шинэчлэлийг бий болгох;
- Нээлттэй, ил тод хариуцлагатай төрийг бий болгох, авлигатай тэмцэх;
- Ядуурлыг бууруулах, тогтвортой цогц хөгжил, хамтын ажиллагааг бий болгох;
- Нийгмийн хариуцлага, нийгмийн түншлэлийг бий болгох;
- Байгалийн нөөц баялгийн менежментийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- Мэдлэг чадвартай, хариуцлагатай иргэдийг төлөвшүүлэн иргэдийн оролцоог бүх түвшний шийдвэр гаргах үйл явцад бий болгох зэрэг болно.

Иргэний нийгмийн байгууллагаас нийтийн төлөө үзэл бодлоо хамгийн хүчтэй илэрхийлдэг байгууллага бол төрийн бус байгууллага. Төрийн бус байгууллага гэж “иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-с бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг[19] хэлнэ. Мөн "албан ёсны бүртгэлтэй, бие даасан, ашиг орлого үл хуваарилах, өөрийн удирдлагатай, сайн дурын үйл ажиллагаатай байх нөхцлүүдийг бүрдүүлж, хууль, эдийн засаг, үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлогдсон байгууллага[20]. ТББ-н нэг хэсгийг сайн дурынхан бүрдүүлдэг, өөрийн удирдлагын арга барилтай (удирдах зөвлөл) санхүүжилт нь мөнгөөр хэмжигдэхгүй, хандивлах, ашиг орлого үл хуваарилах зарчимтай,

[15] MercyCorps; Иргэдийн дуу хоолой сэтгүүл, 2009 оны XI сар, Дугаар 01/09/.1 дэх тал
[16] Хууль зүйн дотоод хэргийн яам; “Шүүх эрх зүйн шинэчлэлт “ төсөл. Төрийн онолын гарын авалга. Улаанбаатар 2007. 49 дэх тал
[17] MercyCorps; Иргэдийн дуу хоолой сэтгүүл, 2009 оны XI сар, Дугаар 01/09/1 дэх тал
[18] MercyCorps; Иргэдийн дуу хоолой сэтгүүл, 2009 оны XI сар, Дугаар 01/09/1 дэх тал
[19] Монгол улсын төрийн бус байгуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг
[20] Salamon L.M; Partners in public service. 1997.

нийгмийн сайн сайхны төлөө ажиллах хүсэл сонирхолтой байх зэрэг үнэт зүйлсийг агуулдаг[21].

Иргэний нийгэм/иргэд төрийн хооронд бодит харилцаа тогтоох нь нээлттэй сайн засаглалын үндсэн суурь нөхцлийг бүрдүүлнэ[22]. Хүчирхэг төр үгүй үед иргэдийн идэвхтэй оролцоо оршин тогтнож, хүчтэй төрийн үед иргэдийн оролцооны цар хүрээг багасдаг гэж үздэг.

Төр, иргэний нийгмийн харилцааг олон хүчин зүйлс (улс төрийн дэглэм, засгийн газрын сонирхлын баримтлах чиг хандлага) тодорхойлдог. Санаачлагатай хамтын оролцоо: засгийн газар улс төрийн зөвшилцөл бий болгохын тулд зохион байгуулалттай ашиг сонирхлыг дайчлахыг хэлдэг. Иргэдийн талаарх засгийн газрын олон талт аргачлалууд засаглалын тодорхой томъёоллыг бүрдүүлдэг. Иргэний нийгэм/иргэд, төрийн харилцаа сайн засаглал, тогтвортой хөгжлийг бий болгоход чухал үүрэгтэй ба түүнчлэн иргэний нийгэм иргэд, нийтийн удирдлагын байгууллага, бизнесийн байгууллагын холбогч гүүр болдог. Иргэд, бизнесийн байгууллагууд эрх ашгаа хамгаалж, үзэл бодлоо төрийн өмнө илэрхийлдэг. Төрөөс дэмжлэг авалгүй, иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдсэн нийгмийн хэсэг бүр нь иргэний нийгэм.

Иргэний нийгэм дээрх бүлгүүдийн үзэл бодол, ашиг сонирхлын нийлэмж бол төрийн бодлогын гол агуулга юм. Иргэний нийгэм нийгмийн баялгийг оновчтой хуваарилах төрийн бодлогын чиглүүлэгч[23]. Иргэний нийгмийн байгууллагын чухал шалгуур үзүүлэлт бол төрөөс эсвэл байгууллагаас хараат бусаар эвлэлдэн нэгдэх явдал. Иргэний нийгмийн байгууллага хараат байх нь нийгэмд сөрөг хандлага бий болгон хэн нэгний эрх ашгийн төлөө үйлчилнэ. Иргэний нийгмийн төлөвшил иргэн, иргэд хоорондын, төр, бие хүн, нийгмийн хоорондын харилцаанд соёл нэвтэрсэн, харилцан эрх, үүрэг хүлээсэн, хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байх хөгжлийн үе шат юм[24]. Хөгжлийн баталгаа нь нийгэм, төр, бие хүний хөгжих, төлөвших, тэгш эрхтэй байх харилцан хүлээх үүргийн тэнцвэрийг хангах явдал[25].

Иргэний нийгэм, төр харилцан хяналттай, тэнцвэртэй оршсоноор нийгэм тогтвортой байх нөхцөл бүрдэнэ. Төр, иргэний нийгмийн харилцаа тогтвортой нөхцөлд хувийн болон нийтлэг эрх ашиг хослон нийгэм хөгжих боломж нээгддэг. Иргэний нийгэм хэт давамгайлвал нийгэмд анархизм харин төрийн эрх мэдэл нийгэмд хэт хүчирхэгжвэл тоталитаризмыг бий болгодог[26]. Иймд төр ба иргэний нийгмийн харилцааг хуулиар зохицуулж, эрх үүргийг нийтээрээ хэлэлцэж, чиг үүргийг тодорхой болгох шаардлагатай. Төр, иргэний нийгэм уялдаатай байж эрх зүйн механизм төлөвшдөг бол ардчилсан бус улсад иргэний нийгэм идэвхгүй,

[21] Mahonti M; Singh A ; The role of the state in voluntarism and voluntary organization-government relationship in India New Delhi 2001
[22] Angelita Gregorio-Medel; Иргэдийн оролцоо ба чадавхын хөгжүүлэлт, NUM leadership олон улсын эрдэм шинжилгээний хуралын эмхэтгэл. УБ., 2014. 66 дахь тал
[23] “Шууд ардчилал хүрээлэн” ТББ. Иргэний нийгэм гэж юу вэ? УБ., 2015. 6 дахь тал
[24] Н.Бурмаа . Төрийн хяналт. УБ., 2016. .46 дахь тал
[25] Н.Бурмаа. Нийтийн удирдлага. УБ., 2018. 572 дахь тал
[26] Н.Бурмаа. Төрийн үйлчилгээ. УБ., 2021. 59 дэх тал

айдаст автсан эсвэл төрийн эсрэг хэт сөрөг хүчин болж хувирдаг[27]. Төр, иргэний нийгэм эв нэгдэлтэй оршихын зэрэгцээ харилцан хяналттай, тэнцвэржиж байдаг нийгмийн хүч мөн[28].

**Гурав. Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо**

Иргэдийн оролцоо сонгуульд оролцож саналаа өгөх, сонгуулийн үйл ажиллагааг хянах, үнэлэх, бодлого, төсөв боловсруулахад оролцох, бодлого хэрэгжүүлэхэд оролцох, үйл ажиллагааны (төсөв) хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээ өгөх, хариуцлага тооцох зэрэг үйл ажиллагаанд чухал нөлөөтэй.

Төрийн захиргаа удирдлагад иргэдийн оролцооны талаар Нэгдсэн үндэстний байгууллагаас "Төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэд тодорхой арга хэмжээ, арга хэрэгслийн тусламжтай оролцох тухай тусган төрийн бодлого, хөтөлбөрт нөлөөг үзүүлэх замаар нийгэм, эдийн засгийн амьдралд эерэг нөлөө үзүүлдэг" хэмээн байр сууриа илэрхийлжээ.

Төрийн бодлогод үндэсний түвшинд парламентаас баталж буй хууль, тогтоол, засгийн газрын тогтоол, шийдвэр, төрийн бодлогын баримт бичиг харин орон нутгийн түвшинд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр, орон нутгийн дэд хөтөлбөр, Засаг даргын тушаал шийдвэр багтдаг[29].

Төрийн бодлого дараах олон нарийвчилсан хэсгээс бүрддэг. Төрийн бодлогын шийдвэр төлөвлөх, гүйцэтгэх, үнэлж дүгнэх, шийдвэр гаргах үйл ажиллагаатай нягт уялдан цаашдын арга хэмжээний хүрээ, түвшин өөр өөр байна.

Төрийн бодлого харилцан уялдаа холбоо бүхий систем бөгөөд иргэд төрийн бодлогын үйл явцад оролцох нь ардчилал, иргэдийн оролцоо, иргэний нийгмийн хөгжилд нэн тустай. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох нь иргэдийн улс төрийн эрхээр тодорхойлогдон төрийн эрх мэдлийг хязгаарлах, хяналт тавих боломжтой. Нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх үндэс, суурь нь төрийн бодлогыг оновчтой боловсруулах, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх явдал. Бодлогын зорилтот хөтөлбөрүүдийн үр дүнг сайжруулахад оролцогч талууд: Парламент, засгийн газар, иргэд, хувийн салбар, ТББ, иргэний нийгэм, ОУБ, хандивлагч байгууллагуудын үүрэг их[30].

Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоог Laband /1911/ тодорхойлохдоо: улс орон ард иргэдгүй бол улс орон биш, ард иргэдийн оролцоогүйгээр үйл ажиллагаа явуулах нь анархистуудын үйл ажиллагаа бөгөөд ардчилал нь ардчилал биш болж хувирна гэжээ. Энэхүү оролцоо санал өгөх, сонгуульд оролцох, орон нутгийн түвшинд улс төрийн амьдралд оролцох, иргэний нийгэм, сонирхлын бүлгийн гишүүн, төрийн болон төрийн захиргааны

[27] Н.Лүндэндорж Төрийн онол. УБ., 2008. 112 дахь тал
[28] Б.Чимид . Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 151 дэх тал
[29] Н.Мягмарцоож .Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо, УБ., 2012.41 дэх тал
[30] МУИС-ОУХНУС Н.Бурмаа ; PUAD 220 Төрийн удирдлага хичээл ийн лекц №4.

байгууллагын түвшинд харилцах, жагсаал цуглаанд оролцон үзэл бодлоо илэрхийлэх хэлбэрээр илэрдэг.

## Дүгнэлт

Төрийн бодлогын үйл явцад хяналтыг хэрэгжүүлснээр цаг хугацаа, зардал хэмнэдэг. Төрийн бодлогын үйл явц дахь хяналтын үр дүн хянаж буй субьектын мэдлэг, ур чадвараас ихээхэн шалтгаална.

Төрийн бодлогын үйл явц цогц систем бөгөөд иргэд бүхий л үе шатанд оролцох нь ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй Ардчилсан засаглалын суурь зарчим болох сайн засаглал, хариуцлагатай, ил тод, нээлттэй байдлыг бий болгох үүднээс төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудал чухал.

Хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох, нийгмийн эрэлт шаардлагад нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад иргэд, олон нийтийн оролцоо чухал бөгөөд төрийн зүгээс гадаад, дотоодын оролцогч талуудаас тавьж буй шахалт, шаардлагад илүү мэдрэмжтэй хандах нь зүйтэй. Иргэдийн оролцооны нэг давуу тал нь засгийн газрын эрх мэдлийг хязгаарлахын зэрэгцээ иргэд бусад хүмүүсийн үзэл бодлыг сонсож чадахгүй нөхцөлд засгийн газар мэдээллийн зуучлагч болдгоороо онцлогтой.

## Эх сурвалжийн жагсаалт


-Батсүх Ш, Доржжав Я, Ганцоож Б; “Шууд ардчилал иргэдийн оролцоо” УБ„ 2014 он

-Батсүх Ш; Ардчилалд иргэдийн идэвх, оролцоо чухал болох нь сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралын эмхэтгэл, УБ., 2015 он

-Бурмаа.Н “Төрийн хяналт” УБ., 2016 он

-Бурмаа.Н “Төрийн үйлчилгээ”. УБ., 2021 он

-Лүндэндорж Н; “Төрийн онол” УБ., 2008 он

-Мягмарцоож Н; “Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо" УБ.,2012 он

-Хууль зүйн дотоод хэргийн яам; “Шүүх эрх зүйн шинэчлэлт" төсөл. Төрийн онолын гарын авлага. УБ., 2007 он

- “Шууд ардчилал хүрээлэн” ТББ. Иргэний нийгэм гэж юу вэ? УБ., 2015 он

-МУИС-ОУХНУС ред Н.Бурмаа “Нийтийн удирдлага". УБ., 2018 он

-Чимид Б: Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он

-Политологи сэтгүүл УБ., 2002, 2012 он

-MercyCorps; Иргэдийн дуу хоолой сэтгүүл, 2009 оны XI сар, Дугаар 01/09/

-NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ 2014 он

-Монгол улсын төрийн бус байгуулгын тухай хууль 1997 оны 1 сарын 31ны өдөр

-Salamon L.M; Partners in public service. 1997.

-Mahonti M; Singh A ; The role of the state in voluntarism and voluntary organization-government relationship in India New Delhi 2001